



СТЕП ГОЛД ХХК

МЭДЭЭЛЛЭХ БОДЛОГО

Степ Голд ХХК ("Степ" буюу "Компани" гэх) нь өөрийн бизнесийг өргөжүүлэх, хувьцаа эзэмшигчдийн ашиг орлогыг нэмэгдүүлэхийн зэрэгцээ өөрийн бизнесийн үйл ажиллагаандаа нэгдмэл, шударга, хариуцлагатай байдлын дээд зэргийн стандартыг нэвтрүүлэн ажиллах зорилготой. Компанийн бизнесийн үйл ажиллагааг удирдан зохицуулах удирдамж, зарчмуудыг Бизнесийн ёс зүйн дүрэмд нарийвчлан заасан бөгөөд уг дүрмийг Компанийн веб хуудас болох www.steppegold.com цахим хуудаснаас үзэх боломжтой. Энэхүү бодлогоор Хөдөлмөр, Хөдөлмөрийн аюулгүй байдал, санхүү, нягтлан бодох бүртгэлийн асуудал, дотоод хяналт, авлига, хээл хахуультай тэмцэх үйл ажиллагаа болон ёс зүйн зөрчил болон бусад үйл ажиллагаатай холбоотой санал, гомдол, мэдээллийг өгөх, хүлээн авах, хадгалах, хамгаалах, мэдээлэгчийг нууцлах, хянан шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Энэхүү Мэдээлэх бодлогын ("Бодлого" гэх) зорилго нь ажилтнууд, захирлууд, албан тушаалтнууд болон зөвлөхүүд ("Төлөөлөгчид" гэх) – ийг санхүүгийн асуудалтай холбоотой санал гомдол, асуудлуудыг нийтийн хүртээл болгох боломжоор хангах зорилготой. Энэхүү Бодлогоор гомдол, санал, асуудлыг хэрхэн, хаана өгөх, санал гомдлыг хэрхэн шийдвэрлэх, боловсруулах, баримтжуулах, санал гомдлыг хэн зохицуулах талаар тодорхойлно. Энэхүү Бодлого нь Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, эрх бүхий байгууллагын журам, заавар болон компанийн дотоод журмуудтай нийцсэн байна.

1. Энэхүү Бодлогыг танилцуулах нь

Энэхүү Бодлогын хуулбарыг биечлэн өгөх, эсвэл Компанийн веб хуудас www.steppegold.com дээр байрлуулах замаар бүх Төлөөлөгчдөд хүргэнэ. Томоохон өөрчлөлтүүдийг хийсэн тохиолдолд бүх Төлөөлөгчдөд мэдэгдэнэ. Шинэ Төлөөлөгчдөд энэ Бодлогын хуулбарыг өгнө.

2. Гарсан зөрчил, гомдлыг мэдээлэх нь

2.1 Асуудлыг мэдээлэх нь

Компани нь нээлттэй-хаалганы бодлого баримталдаг бөгөөд бүх Төлөөлөгчдөд аливаа асуудал, санал, гомдлыг зохистой шийдвэрлэж чадах хэн нэгэнтэй тэдгээр асуудал, санал гомдлоо хуваалцах боломжийг олгодог. Степд хамаарах санхүүгийн асуудалтай холбоотой аливаа асуудлыг Компанийн Аудитын Хорооны Даргад ("Аудитын Хорооны Дарга") бичгээр, утсаар эсвэл цахилгаан шуудангаар дараах хаягаар ирүүлнэ.:

Бичгээр: Хаяг: Монгол Улс, Улаанбаатар-14241, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Шангри-Ла оффис 1201 тоот; Дотоод хяналтын албаны даргад
Утас: 976 7732 1914
Факс: 976 7732 1914
Цахим шуудан: jamtskhand@steppegold.mn

2.2 Нэргүй мэдээлэл ба нууцлал

Компани болон энэхүү Бодлогын дагуу санал гомдлыг шийдвэрлэх үүрэг бүхий этгээдүүд бүхий л мэдээллийг хангалттай хяналт шалгалтад үндэслэн шийдвэрлэх шаардлагын дагуу хуулийн хүрээнд, асуудлыг аль болох дээд зэргээр нууцлалтай авч үзнэ. Компани нягтлан бодох бүртгэх болон аудитын эргэлзээтэй асуудлуудтай холбоотой нууцлалтай, нэргүй мэдээлэл, санал гомдлыг Аудитын Хороонд хүргүүлэх тусгай журамтай байдаг. Ийм төрлийн бүхий л санал гомдол, мэдээллийг энэхүү Бодлогын 3.1 дахь хэсэгт дурдсан хаягаар Аудитын Хорооны Даргад бичгээр ирүүлнэ. Захидал бичгийг **“НУУЦЛАЛТАЙ”** хэмээн тод гаргацтай тэмдэглэнэ.

3. Өс санахгүй байх

Энэхүү Бодлогын дагуу мэдэгдэх асуудалтай холбогдуулан мэдээллийг чөлөөтэй өгөх боломжоор хангах, мэдээлэл өгсөн хүнийг ямар нэгэн хэлбэрийн шийтгэл оногдуулах, сөрөг хариу үйлдэл гаргах, ажлаас халах, түдгэлзүүлэх, албан тушаал бүүруулах, өөр албан тушаалд шилжүүлэх, гутаан доромжлох, ялгаварлан гадуурхах зэрэг хөдөлмөр эрхлэлттэй нь холбоотой аливаа болзошгүй сөрөг үр дагавараас хамгаалах (**“өс санахгүй байх”**) бодлогыг Компани баримтлан ажилладаг. Энэхүү Бодлогын дагуу илэрсэн зөрчилтэй холбогдуулан мэдээлэл өгсөн Төлөөлөгч бүрийг энэхүү Бодлогоор ямар нэгэн хэлбэрийн өс санах аливаа үйлдлээс хамгаална. Энэхүү Бодлогын дагуу зөрчлийг шударгаар мэдээлсэн хэн нэгний эсрэг өс санаж, сөрөг хариу үйлдэл үзүүлсэн аливаа Төлөөлөгчдөд хөдөлмөр эрхлэлтийг нь дуусгавар болгох хүртэл арга хэмжээ авч болно. Энэхүү Бодлого нь Төлөөлөгчид болон бусад этгээдүүдийг Компани доторхи аливаа ноцтой асуудлыг зохистой шийдвэрлүүлэхийн тулд ил гаргахад нь хөхүүлэн дэмжих зорилготой.

4. Шударгаар үйлдэх нь

Энэхүү Бодлогын дагуу Санал, гомдол, мэдээлэл нь үнэн зөв, бодитой, үндэслэл бүхий байна. Бусдын нэр, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан, гүтгэсэн, доромжилсон санал, гомдол, мэдээлэл гаргахыг хориглоно. Үндэслэлгүй гаргасан аливаа гомдол мэдээллийг нотлох боломжгүй бөгөөд санаатайгаар төөрөгдүүлсэн, эсвэл хорлох санаатай мэдээлэл өгсөн нь нотлогдвол үүнийг ноцтой зөрчил гэж үзнэ.

5. Баримт, бичлэгийг хадгалах

Аудитын хороо нь ямар нэгэн санхүүгийн асуудал, хариу арга хэмжээний тухай тайлан, тухайн тайлангуудын шалгалтын үр дүнгийн талаарх баримт сэлт, бичлэгийг тодорхой хугацаагаар хадгална. Аудитын хороонд хадгалагдах баримт, бичлэгийн төрлүүдэд хяналт шалгалттай холбогдуулан авсан бүхий л арга хэмжээ болон хяналт шалгалтын үр дүнгийн тайлан багтана.

6. Гуравдагч этгээдүүдээс ирэх санал гомдол

Үнэт цаасны тухай хуулиар Компани нь санхүүгийн асуудалтай холбогдуулан аливаа санал гомдлыг хүлээн авах, хадгалах, шийдвэрлэх журмыг гаргах шаардлагатай байдаг. Үүнд мөн гуравдагч этгээдүүдээс ирсэн санал гомдол багтана. Тиймээс, аливаа гуравдагч этгээдээс /Компанийн хараат бус аудитор мөн багтана/ ирсэн дээрх асуудалтай холбоотой санал гомдлыг төлөөлөгч бүр Аудитын Хорооны даргад илгээнэ.

Аудитын Хорооны дарга нь тухайн санал гомдлуудыг Аудитын Хорооны хуваарьт ээлжит хурал (тэдгээр нь үндэслэлгүй биш бол, эсвэл санал гомдлын агуулга нь ээлжит бус хурлыг хуралдуулахад хүргээгүй бол) дээр хэлэлцэнэ.

Төлөөлөн Удирдах Зөвлөл нь, цаашид, энэхүү Бодлогын нөхцлөөс хазайхыг зөвшөөрч болно. Энэхүү Бодлого нь Компани, түүний захирлууд, ажилтнууд, хувь нийлүүлэгчид, үнэт цаас эзэмшигчид, үйлчлүүлэгчид, ханган нийлүүлэгчид, өрсөлдөгчид, ажилчид болон бусад этгээдэд иргэний хариуцлага хүлээлгэх, эсвэл бусад төрлийн хариуцлага хүлээлгэх зорилго агуулаагүй болно.

7. Бодлогын хэрэгжилтийг дүгнэх

Хууль эрх зүйн болон санхүүгийн асуудалтай холбоотой аливаа зөрчил, санал гомдлыг нууцлалтайгаар, нэргүй мэдээлэх үйл явцыг хэрэгжүүлэхэд энэхүү Бодлого үр дүнтэй байсан эсэхийг тогтоох зорилгоор Аудитын Хороо жил бүр энэхүү Бодлогын хэрэгжилтэд үнэлэлт, дүгнэлт өгнө.

8. Лавлах зүйлс

Хэрэв тодорхой нөхцөлд энэхүү Бодлогыг хэрхэн мөрдөх талаар асууж лавлах зүйл байвал, Аудитын Хорооны Даргатай холбогдоно уу.

9. Бодлогыг веб хуудас дээр нийтлэх нь

Энэ Бодлогыг Компанийн веб хуудас: www.steppegold.com. дээр нийтлэнэ.

Хамгийн сүүлд батласан огноо: 2017 оны 10 сарын 2

Батласан: Аудитын Хороо

Төлөөлөн Удирдах Зөвлөл